



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2026 оны I улирлын санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	4
Товчилсон нэрсийн жагсаалт	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт	7
Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	8
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт	8
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт	8
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт	8
Статистик үзүүлэлтүүд	9
Харилцагчид, зээлдэгчид	9
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид	9
Тархалт	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	12
Хөрөнгө оруулалт	13
Зээл.....	13
Цахим зээл	16
Ногоон зээл	18
Факторингийн тооцооны авлага.....	20
Үүсмэл санхүүгийн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө.....	20
Санхүүгийн бус хөрөнгө	21
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	21
Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	23
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр.....	24
Бусад эх үүсвэр	24
ББСБ-аас гаргасан өрийн бичиг.....	24
Төслийн зээлийн санхүүжилт.....	25
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ).....	26
Бусад санхүүгийн өр төлбөр.....	26
Санхүүгийн бус өр төлбөр	26
Өөрийн хөрөнгө	26
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	27
Өөрийн хөрөнгийн бусад хэсэг	28
Хуримтлагдсан ашиг	28
Ашигт ажиллагаа	29
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	30
Өгөөжийн үзүүлэлтүүд	30
Гадаад валютын арилжааны мэдээ	31
Дүгнэлт	31
Актив, пассивын бүтэц.....	32
Ашигт ажиллагаа	33
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	33

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр).....	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа	5
Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл.....	9
Хүснэгт 5 Статистик мэдээлэл (5 жилээр)	9
Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл	10
Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр).....	11
Хүснэгт 11 Активын интервал (тэрбум төгрөгөөр).....	12
Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)	12
Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц (сая төгрөгөөр)	13
Хүснэгт 14 Зээлийн бүтэц (тэрбум төгрөгөөр).....	13
Хүснэгт 15 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар (сая төгрөгөөр)	15
Хүснэгт 16 Зээлийн ангилал (тэрбум төгрөгөөр)	16
Хүснэгт 17 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр)	16
Хүснэгт 18 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд (мянган төгрөгөөр).....	16
Хүснэгт 19 Ногоон зээлийн тайлан (сая төгрөгөөр)	18
Хүснэгт 20 Факторингийн тооцооны авлагын ангилал (сая төгрөгөөр)	20
Хүснэгт 21 Бусад хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)	20
Хүснэгт 22 Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр).....	21
Хүснэгт 23 Пассивын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр).....	21
Хүснэгт 24 Итгэлцлийн үйлчилгээ (сая төгрөгөөр)	23
Хүснэгт 25 Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг (сая төгрөгөөр)	24
Хүснэгт 26 Бусад эх үүсвэрийн бүтэц (сая төгрөгөөр)	24
Хүснэгт 27 Төслийн зээл санхүүжилт (сая төгрөгөөр)	25
Хүснэгт 28 Бусад өр төлбөр (сая төгрөгөөр)	26
Хүснэгт 29 Санхүүгийн бус өр төлбөр (сая төгрөгөөр).....	26
Хүснэгт 30 Өөрийн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)	26
Хүснэгт 31 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр).....	27
Хүснэгт 32 ХНХ-ийн интервал (тэрбум төгрөгөөр).....	27
Хүснэгт 33 Бусад өмч, сангуудын бүтэц (сая төгрөгөөр).....	28
Хүснэгт 34 Орлого, үр дүнгийн тайлан (харьцуулсан, сая төгрөгөөр)	29
Хүснэгт 35 Орлого, үр дүнгийн тайлан (тэр төгрөгөөр).....	29
Хүснэгт 36 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд (үзүүлэлт бүрээр).....	30
Хүснэгт 37 2026 оны I улирлын байдлаарх валют арилжааны мэдээ (сая төгрөгөөр)	31

Зургийн жагсаалт

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл).....	11
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)	11
Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	12
Зураг 4 Зээлийн багцын чанар (тэрбум төгрөгөөр)	14
Зураг 5 Зээлийн багцын чанар (хувиар)	14
Зураг 6 Олгосон зээл (хугацааны ангиллаар)	15
Зураг 7 Сүүлийн 5 жилийн байдлаар финтек зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр)	16
Зураг 8 Сүүлийн 3 жилийн байдлаар ногоон зээлийн үлдэгдэл(тэрбум төгрөгөөр).....	18
Зураг 9 Ногоон зээлийн багцын чанар (ногоон таксономийн 12 ангиллаар)	19
Зураг 10 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг).....	22
Зураг 11 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	22
Зураг 12 Итгэлцлийн үйлчилгээний өглөг (тэрбум төгрөгөөр)	23
Зураг 13 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)	24
Зураг 14 Төслийн зээлийн санхүүжилт сүүлийн 5 жилийн байдлаар	25
Зураг 15 Хувьцаат капитал сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	27
Зураг 16 Хуримтлагдсан ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр).....	28
Зураг 17 Тайлант үеийн ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр).....	28
Зураг 18 Ашигт ажиллагааны үзүүлэлт (тэрбум төгрөгөөр).....	29
Зураг 19 Салбарын өгөөжийн үзүүлэлт сүүлийн 5 жилээр	31

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт
СТ	Санхүүгийн тайлан
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ЗМС	Зээлийн мэдээллийн сан

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2026 оны I улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 578 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 3 ББСБ буюу 0.5 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 100 нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 26 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2022-I	2023-I	2024-I	2025-I	2026-I
Шинээр олгосон	6	6	15	2	4
Хүчингүй	11	5	13	-	1
Түдгэлзүүлсэн	4	1	7	-	2
Сэргээсэн	5	10	9	-	-
Нийт ББСБ	529	514	531	575	578
Үүнээс: ХОН	85	94	95	96	100
Үүнээс: ГХО	28	25	24	28	26
Салбар	393	428	462	539	603
Төлөөлөгч	8	7	11	12	10

2026 оны I улирлын байдлаар 4 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 2 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 1 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2026 оны I улирлын байдлаар 82 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	2025-I	2026-I	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	7,568.4	9,570.9	26.5%
Банкны салбартай харьцуулахад хувиар	10.8%	11.3%	0.4%
Нийт өөрийн хөрөнгө	3,884.7	5,135.1	32.2%
Банкны салбартай харьцуулахад хувиар	53.4%	65.0%	11.7%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,820.6	2,333.8	28.2%
Банкны салбартай харьцуулахад хувиар	105.4%	128.7%	23.3%
Нийт зээл	6,325.3	7,767.3	22.8%
Банкны салбартай харьцуулахад хувиар	16.1%	17.0%	0.9%
Нийт орлого	603.4	772.1	28.0%
Нийт зарлага	371.3	500.2	34.7%
Цэвэр ашиг	232.1	271.9	17.1%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар өсөж, банкны салбарын 11.3%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 128.7%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.3 пунктээр өссөн дүн юм.

2026 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар буюу 2.0 их наяд төгрөгөөр өсөж 9.6 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 72.0 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 62.4 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын нийт орлогын хэмжээ 28.0 хувиар буюу 168.8 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 34.7 хувиар буюу 128.9 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 17.1 хувиар буюу 39.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2025-I	2026-I	Тоо	Хувь
	Нийт ББСБ-ын тоо	575	578	3	0.5%
1	Зээл	511	514	3	0.6%
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	<i>311</i>	<i>323</i>	<i>12</i>	<i>3.9%</i>
2	Факторингийн үйлчилгээ	55	61	6	10.9%
3	Төлбөрийн баталгаа гаргах	28	29	1	3.6%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	7	1	16.7%
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	54	56	2	3.7%
6	Гадаад валютын арилжаа	178	167	-11	-6.2%
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	<i>61</i>	<i>64</i>	<i>3</i>	<i>4.9%</i>
7	Итгэлцлийн үйлчилгээ	90	92	2	2.2%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	50	57	7	14.0%
9	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	-	-

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 578 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 88.9% нь буюу 514 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 55.9% нь буюу 323 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын

арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 167 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 28.9 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 64 ББСБ нийт ББСБ-уудын 11.1 хувийг бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үеэс өөрчлөгдсөн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оноос 3 ББСБ-аар буюу 0.6 хувиар, факторингийн үйлчилгээ 6 ББСБ-аар буюу 10.9 хувиар, төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа 1 ББСБ-аар буюу 3.6 хувиар, итгэлцлийн үйлчилгээ 2 ББСБ-аар буюу 2.2 хувиар, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт

хийх үйлчилгээ 7 ББСБ-аар буюу 14.0 хувиар, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 2 ББСБ-аар буюу 3.7 хувиар өссөн бол, гадаад валютын арилжаа 11 ББСБ-аар буюу 6.2 хувиар буурсан байна.

2026 оны I улирлын тайлан мэдээний ирц 97.1% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 578 ББСБ-аас 561 ББСБ жилийн тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 11 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 6 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 31 дүгээр тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д хэрэглээний зээлийн хэт өсөлтийг бууруулах, цахим зээлийн давхардлаас урьдчилан сэргийлэх хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Журмын өөрчлөлтийн хүрээнд дараах зохицуулалтыг тусгасан. Үүнд:

- ББСБ-аас олгох хэрэглээний зээлд тооцох өр, орлогын харьцаа 55 хувиас хэтрэхгүй байх;
- ББСБ нь хэрэглээний зээл олгох бүрд харилцагчийн зээлийн эрхийг тооцоолж, өр орлогын харьцааг хангасан эсэхийг шалгасны үндсэн дээр зээл олгох, ББСБ нь зээл олгосон тухай мэдээллийг бодит цагийн горимоор Зээлийн мэдээллийн санд нийлүүлэх;
- Зээлийн үйл ажиллагааны талаарх сурталчилгаанд зээлийн хүү болон зээлийн гэрээний гол нөхцөлүүдийг тусгасан байх;
- Кредит карт, овердрафт эрхтэй харилцах данс эзэмшдэг зээлдэгчийн хувьд банк, санхүүгийн байгууллагаас тогтоосон зээлийн эрхийн 10 хувиар, финтек зээлийн шугамын эрхтэй зээлдэгчийн хувьд банк бус санхүүгийн байгууллагаас тогтоосон зээлийн эрхийн дүнгээр зээлийн төлбөрт тооцох;
- Харилцагчийн зээлийн лавлагаанд сүүлийн 72 цагийн дотор 5-аас доошгүй банк, санхүүгийн байгууллага зээл судалсан тухай бүртгэгдсэн тохиолдолд зээл судлах хугацааг 24 цагаар хойшлуулж, зээлийн лавлагааг шинэчлэн авсны үндсэн дээр зээл олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2026 оны I улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 68.1 хувь буюу 392 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 64.7 хувь буюу 372 ББСБ хэрэгжүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.

2026 оны I улирлын байдлаар зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 514 ББСБ-ын 90.3 хувь буюу 464 ББСБ Монголбанк, “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ийн аль нэгтэй гэрээ байгуулсан байна

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д

заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 89 ББСБ, 11,362 удаагийн тохиолдлоор, 1,699.2 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ” гэж заасны дагуу нэр бүхий 3 ББСБ, 22 удаагийн тохиолдлоор, 1.2 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-д тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2026 оны I улирлын байдлаар нийт 578 ББСБ, 1 банкнаас 1,496.0 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс 90.0% буюу 522 ББСБ, 1 банкны 1,381.1 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2026 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 44,439 хувьцаа эзэмшигчдийн 578 ББСБ, 603 салбар нэгж, 10 төлөөлөгчийн газар, 6,866 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.3 сая харилцагчид үйлчилгээ үзүүлж, 3.5 сая зээлдэгчид /давхардаагүй 768,150/ хүрч үйлчилж байна.

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар өсч давхардсан тоогоор 4,347,995 зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 34.3 хувиар өсөж 3,467,471-т хүрсэн байна.

Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	4,347,995	3,344,241	285,522	4,062,473	35,366	4,286,249	61,746	556,247	112,990
Үүнээс: Эмэгтэй	2,314,034	1,757,516	159,894	2,154,140	16,595	2,282,692	31,342	298,685	58,899
Эрэгтэй	2,024,157	1,584,886	117,524	1,906,633	12,209	1,993,829	30,328	256,733	53,652
Хуулийн этгээд	9,804	1,839	8,104	1,700	6,562	9,728	76	829	439
Итгэмжлэгчдийн тоо	16,941	16,939	804	16,137	-	16,893	48	7,154	405
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,801	1,709	231	1,570	-	1,801	-	382	1
Зээлдэгчдийн тоо	3,467,471	2,682,137	117,308	3,350,163	39	3,407,862	59,609	227,858	112,980
Хэвийн	2,997,609	2,331,334	91,373	2,906,236	17	2,954,137	43,472	180,181	96,019
Хугацаа хэтэрсэн	155,545	120,670	5,988	149,557	-	152,650	2,895	15,485	4,584
Чанаргүй:	314,317	230,133	19,947	294,370	22	301,075	13,242	32,192	12,377
-Хэвийн бус	90,748	67,454	4,566	86,182	4	87,793	2,955	8,826	3,107
-Эргэлзээтэй	108,587	81,248	3,800	104,787	1	102,794	5,793	14,266	6,587
-Муу	114,978	81,431	11,577	103,401	17	110,484	4,494	9,100	2,683
Зээлдэгчдийн насжилт	3,464,828	2,680,730	115,764	3,349,064	39	3,405,291	59,537	227,454	112,541
18-25 насны	598,660	449,580	12,245	586,415	20	589,924	8,736	35,479	16,462
26-35 насны	1,390,953	1,073,966	33,212	1,357,741	19	1,368,588	22,365	85,028	42,353
36-45 насны	977,756	774,590	40,110	937,646	-	964,635	13,121	69,537	33,917
46-55 насны	407,196	310,597	21,533	385,663	-	393,831	13,365	29,458	15,302
55-аас дээш	90,263	71,997	8,664	81,599	-	88,313	1,950	7,952	4,507
Зээлдэгчдийн боловсрол	3,464,830	2,680,730	115,766	3,349,064	39	3,405,291	59,539	227,454	112,541
-Дээд	1,763,464	1,373,547	53,966	1,709,498	30	1,735,865	27,599	131,427	74,360
-Тусгай дунд	549,774	427,151	7,988	541,786	-	544,031	5,743	22,155	14,767
-Бүрэн дунд	854,071	621,000	34,276	819,795	9	830,323	23,748	58,300	14,729
-Дунд	245,438	212,182	15,587	229,851	-	243,670	1,768	13,611	6,044
-Бага	52,083	46,850	3,949	48,134	-	51,402	681	1,961	2,641

(Финтек ББСБ-ууд цахим, уламжлалт зээл хослуулан олгодог болно)

Нийт харилцагчдын 93.4% буюу 4,062,473, зээлдэгчдийн 96.6% буюу 3,350,163 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж (финтек), онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 6.6% буюу 285,522 зээлдэгчдийн 3.4% буюу 117,308 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 35,175 буюу нийт харилцагчдын 0.8 хувийг бүрдүүлж байна.

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Хүснэгт 5 Статистик мэдээлэл (5 жилээр)

Үзүүлэлтүүд	2022-I	2023-I	2024-I	2025-I	2026-I	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	21,778	28,353	33,850	35,807	44,439	8,632	21,778
Ажилчдын тоо	4,322	4,735	5,385	6,197	6,866	669	4,322
Харилцагчдын тоо	4,645,134	3,862,489	4,458,031	3,739,313	4,347,995	608,682	4,645,134
Зээлдэгчдийн тоо	3,862,489	1,297,025	1,800,942	2,581,334	3,467,471	886,137	3,862,489
Зээлийн жигнэсэн дундаж хүү	3.1%	3.1%	3.6%	3.5%	3.6%	0.1%	

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 24.1 хувиар буюу 8,632-оор өсч 44,439-т хүрчээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 97.4 хувь буюу 43,292 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,147 буюу 2.6% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 3,202 буюу 7.2% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 220 буюу 0.5% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа

эзэмшигчид байна. ББСБ-ын салбарын нийт ажилтнуудын тоо өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар буюу 669 ажилтнаар нэмэгдэж 6,866-д хүрсэн байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	44,439	43,522	1,951	42,488	89	44,219	220	43,292	3,202
Нийт ажилтнуудын тоо	6,866	4,538	2,525	4,341	162	6,569	297	625	515
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	4,149	2,734	1,516	2,633	88	3,942	207	405	330
Эрэгтэй ажилтны тоо	2,717	1,804	1,009	1,708	74	2,627	90	220	185

Хөдөө орон нутгийн 100 ББСБ 7 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	578	92	496	82	64	478	100	5	573	26
1 Зээл	514	92	432	82	-	419	95	5	509	25
2 Факторингийн үйлчилгээ	61	39	27	34	-	57	4	3	58	1
3 Төлбөрийн баталгаа гаргах	29	17	18	11	-	28	1	3	26	3
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	7	6	-	7	-	7	-	1	6	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	56	28	28	28	3	54	2	3	53	2
6 Гадаад валютын арилжаа	167	37	135	32	64	151	16	5	162	9
7 Итгэлцлийн үйлчилгээ	92	92	44	48	-	88	4	5	87	5
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	57	35	29	28	-	54	3	3	54	3
9 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	1	-	-	1	-	-	1	1

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 82.7% буюу 478 ББСБ, салбаруудын 58.5% буюу 353 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 17.3% буюу 100 ББСБ, салбаруудын 41.3% буюу 249 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2026 оны I улирлын байдлаар 123 ББСБ-ын 603 салбар бүртгэлтэй байгаа ба эдгээрийн 56.9 хувийг 15 ББСБ-ын 343 салбар бүрдүүлж байна. Мөн Австрали улсад 1 салбар бүртгэлтэй байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн 478	Салбар 353	Нийт 831	Хувь 100.0%
1. Сүхбаатар	163	48	211	25.4%
2. Чингэлтэй	122	31	153	18.4%
3. Баянзүрх	57	87	144	17.3%
4. Баянгол	63	53	116	14.0%
5. Хан-Уул	64	43	107	12.9%
6. Сонгинохайрхан	8	78	86	10.3%
7. Багануур	1	7	8	1.0%
8. Налайх	-	6	6	0.7%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Дархан-Уул, Төв, аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн 100	Салбар 249	Нийт 349	Хувь 100%
Архангай аймаг	2	7	9	2.6%
Баян-Өлгий аймаг	3	6	9	2.6%
Баянхонгор аймаг	4	11	15	4.3%
Булган аймаг	2	2	4	1.1%
Говь-Алтай аймаг	1	4	5	1.4%
Говьсүмбэр аймаг	3	5	8	2.3%
Дархан-Уул аймаг	9	26	35	10.0%
Дорноговь аймаг	4	13	17	4.9%
Дорнод аймаг	6	20	26	7.4%
Дундговь аймаг	0	9	9	2.6%
Завхан аймаг	2	8	10	2.9%
Орхон аймаг	9	24	33	9.5%
Өвөрхангай аймаг	9	16	25	7.2%
Өмнөговь аймаг	2	22	24	6.9%
Сүхбаатар аймаг	5	8	13	3.7%
Сэлэнгэ аймаг	9	13	22	6.3%
Төв аймаг	22	12	34	9.7%
Увс аймаг	2	11	13	3.7%
Ховд аймаг	1	10	11	3.2%
Хөвсгөл аймаг	2	10	12	3.4%
Хэнтий аймаг	3	12	15	4.3%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2026 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 9.6 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.5 хувиар буюу 2.0 их наяд төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 72.0 хувийг нийт зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр)

Активын үзүүлэлтүүд	2025-I		2026-I		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Дүн	Дүн	Хувь
САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,223,524.2	95.4%	9,110,992.6	95.2%	1,887,468.4	26.1%
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	662,130.5	8.7%	1,005,308.0	10.5%	343,177.5	51.8%
Хөрөнгө оруулалт	89,510.1	1.2%	143,645.3	1.5%	54,135.2	60.5%
Зээл (цэврээр)	6,263,240.7	82.8%	7,619,830.0	79.6%	1,356,589.3	21.7%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	51,927.5	0.7%	103,833.7	1.1%	51,906.3	100.0%
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	4,706.6	0.1%	3,199.8	0.0%	-1,506.7	-32.0%
Бусад санхүүгийн хөрөнгө	152,008.9	2.0%	235,175.7	2.5%	83,166.8	54.7%
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	344,862.2	4.6%	459,865.9	4.8%	115,003.8	33.3%
Санхүүгийн бус бусад хөрөнгө	129,371.0	1.7%	214,023.3	2.2%	84,652.3	65.4%
Үндсэн хөрөнгө (цэврээр)	150,087.4	2.0%	179,144.3	1.9%	29,056.9	19.4%
Биет бус хөрөнгө (цэврээр)	65,403.7	0.9%	66,698.3	0.7%	1,294.6	2.0%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,568,386.4	100.0%	9,570,858.5	100.0%	2,002,472.2	26.5%


2026 оны I улирлын байдлаар ББСБ-уудын нийт актив банкны салбарын нийт активын 11.3 хувьтай, нийт зээлийн үлдэгдэл 17.0 хувьтай тэнцэж байна.

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл)



Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2022 оны I улиралд 2,972.8 тэрбум төгрөг байсан бол 2026 оны I улирлын байдлаар 3.2 дахин өсөж 9,570.9 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь нийт зээлийн үлдэгдэл 3.4 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Салбарын нийт хөрөнгийн 98.6% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 420 ББСБ, 0.4% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 27 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 1.0 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 141 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал (тэрбум төгрөгөөр)

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	8,711.0	213	91.0%	36.9%	30.1	3	23.4	3	-	-
2.5-5.0 тэрбум	730.2	207	7.6%	35.8%	4.1	1	19.0	5	12.6	4
1.9-2.5 тэрбум	38.1	17	0.4%	2.9%	2.1	1	8.9	4	1.9	1
1.4-1.9 тэрбум	23.0	14	0.2%	2.4%	7.1	4	7.5	5	3.1	2
0.6-1.4 тэрбум	39.9	43	0.4%	7.4%	8.7	9	20.0	21	9.9	12
0.6 тэрбум хүртэлх	28.6	84	0.3%	14.5%	-	-	13.4	44	16.5	45
НИЙТ	9,570.9	578	100.0%	100.0%	52.1	18	92.1	82	44.1	64

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 5.6 их наяд төгрөг байгаа нь нийт активын 58.9 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 4.7 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 61.0 хувийг бүрдүүлж байна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 343.2 тэрбум төгрөгөөр буюу 51.8 хувиар өсч 1,005.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 8.9 хувь нь бэлэн мөнгө хэлбэрээр, 69.8 хувь нь 3 хүртэлх сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад, 19.7 хувь нь 3-аас дээш сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад, 1.6 хувь нь мөнгөн хөрөнгөд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,005.3	638.6	427.3	578.0	37.1	983.5	21.8	205.4	147.5
Бэлэн мөнгө	89.8	5.5	82.4	7.4	24.6	79.8	9.9	0.8	2.1
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	701.3	461.4	247.1	454.2	11.9	691.4	9.9	187.7	131.4
Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	-	-	-	-	-	-	-	-	-
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (3-аас дээш сарын хугацаатай)	16.2	11.2	7.0	9.2	0.0	16.2	-	-	-

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 19.3%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 1.3%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 66.3% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 60.5 хувиар буюу 54.1 тэрбум төгрөгөөр өсөж, 2026 оны I улирлын байдлаар 49 ББСБ 143.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Хөрөнгө оруулалтын 7.7 хувь буюу 11.1 тэрбум төгрөг нь хадгаламжийн сертификат, 92.3 хувь буюу 132.5 тэрбум төгрөг нь үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл	Уламж- лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	143,645.3	132,621.3	14,608.6	129,036.7	1.0	140,701.2	2,944.1	63,994.3	49,193.3
Хадгаламжийн сертификат	11,107.0	7,107.0	4,000.0	7,107.0	-	11,107.0	-	-	-
Үнэт цаас	132,538.3	125,514.3	10,608.6	121,929.7	1.0	129,594.2	2,944.1	63,994.3	49,193.3
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	49,803.3	44,196.4	7,419.5	42,383.8	-	46,859.3	2,944.1	7,875.6	500.0
Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаас	41,235.9	41,233.9	1,773.0	39,462.9	1.0	41,235.9	-	29,075.4	27,075.4
Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	40,413.1	39,011.3	1,402.8	39,010.3	-	40,413.1	-	26,719.5	21,294.1
Барьцаанд байгаа үнэт цаас	-	-	-	-	-	-	-	-	-
Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,490.2	1,476.9	13.4	1,476.9	-	1,490.2	-	728.0	728.0
(Үнэт цаасны эрсдэлийн сан)	404.3	404.3	-	404.3	-	404.3	-	404.3	404.3

2026 оны I улирлын байдлаар богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөлтэй 57 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 49 ББСБ санхүүгийн тайлангаар хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 36 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 23.6 хувь буюу 1.6 их наяд төгрөгөөр өсөж 2026 оны I улирлын байдлаар 8.1 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 505.6 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 7.6 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 14 Зээлийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Зээл (цэврээр)	7,619.8	5,943.1	2,124.9	5,494.9	2.2	7,516.8	103.0	1,116.4	764.0
Зээл	8,125.8	6,315.8	2,271.7	5,854.0	2.3	8,015.2	110.6	1,213.2	821.2
Хэвийн	6,604.0	5,161.5	1,824.2	4,779.8	1.8	6,513.8	90.1	943.8	643.7
Анхаарал хандуулах	469.7	390.7	114.6	355.1	-	465.2	4.4	92.7	55.4
Чанаргүй зээл	693.7	507.7	208.0	485.7	0.1	682.0	11.7	125.6	88.4
-Хэвийн бус зээл	206.5	161.0	56.0	150.5	0.1	203.2	3.4	45.8	32.7
-Эргэлзээтэй зээл	216.2	165.0	49.6	166.6	0.0	212.5	3.7	42.6	26.5
-Муу зээл	271.0	181.7	102.3	168.7	0.0	266.3	4.7	37.2	29.1
(ЗЭС)	505.6	372.4	146.8	358.8	0.1	498.1	7.5	96.5	57.0
Хойшлогдсон төлбөр	5.7	5.6	0.1	5.6	-	5.7	0.0	2.6	2.6
Зээлд хур/тооцсон хүүгийн авлага	364.1	261.4	125.1	239.0	0.4	359.8	4.3	53.6	36.3
ЗЗ-ийн хүүнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн зарруулга	0.3	0.3	-	0.3	-	0.3	-	0.3	0.3


(Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно)

Шинэчлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн журамд зааснаар “Санхүүгийн тайланд зээлийг хорогдуулсан өртгөөр хэмжиж, тайлагнана. Зээлийн хорогдуулсан өртөг нь зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах, эсхүл нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна” гэж тодорхойлсон.

Гадаад валютын арилжаа эрхэлдэг нэр бүхий ББСБ-ын 1.9 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь тус ББСБ-ын зээлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг 2024 оны 03 сарын 20-ны 119 дүгээр тогтоолоор хүчингүй болгосонтой холбоотойгоор тайланд үлдэгдэл хэлбэрээр туссан болно.

Тайлант хугацаанд ББСБ-ууд 4.0 их наяд төгрөгийн зээлийг 3.6 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 3.5 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2026 оны I улирлын байдлаар 3.5 сая зээлдэгчийн 7.8 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Зураг 4 Зээлийн багцын чанар (тэрбум төгрөгөөр)



(Нийт зээлийн үлдэгдлийг зээлийн багцын нийлбэрээр тооцсон)

Зээлийн багцын 85.0 хувийг буюу 6.6 их наяд төгрөгийг хэвийн зээл, 6.1 хувийг буюу 469.7 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 8.9 хувийг буюу 693.7 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 5 Зээлийн багцын чанар (хувиар)



Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 3.7 пунктээр буурсан бол, чанаргүй зээлийн хувь 2.2, анхаарал хандуулах зээлийн хувь 1.5 пунктээр тус тус өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 1.2 их наяд төгрөгийн үлдэгдлийн 45.7 хувьд буюу 505.6 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

2026 оны I улирлын байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 15.1% байна.

Олгосон зээлийн 90.4 хувь буюу 3.7 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 9.6 хувь буюу 387.3 их наяд төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 91.2 хувь буюу 3.2 их наяд төгрөг нь иргэдээс, 8.8 хувь нь буюу 307.6 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

2026 оны I улирлын байдлаар 7.8 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа ба үүний 88.3 хувь буюу 6.9 их наяд төгрөгийг иргэдийн, 11.7 хувь буюу 906.1 тэрбум төгрөгийг хуулийн этгээдийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.


Хүснэгт 15 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар (сая төгрөгөөр)

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	25,303.5	0.4%	19,722.3	0.6%	77,668.8	1.0%
2.	Уул уурхай, олборлолт	23,812.9	0.5%	23,863.0	0.7%	90,078.0	1.2%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	23,419.1	0.5%	17,804.3	0.5%	69,755.7	0.9%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3,490.2	0.1%	3,227.3	0.1%	12,941.0	0.2%
5.	Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	1,374.7	0.0%	1,939.9	0.1%	4,021.4	0.1%
6.	Барилга	106,095.9	2.3%	75,832.4	2.2%	367,397.6	4.7%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	285,892.7	6.4%	224,080.3	6.4%	847,985.2	10.9%
8.	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	52,642.4	2.0%	48,013.4	1.4%	178,919.1	2.3%
9.	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	25,232.2	0.7%	34,107.1	1.0%	104,150.3	1.3%
10.	Мэдээлэл, холбоо	8,098.8	0.2%	4,596.6	0.1%	36,461.2	0.5%
11.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	94,255.7	1.7%	77,569.3	2.2%	151,798.2	2.0%
12.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	39,551.4	1.3%	29,837.1	0.9%	105,030.8	1.4%
13.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2,491.4	0.1%	1,590.9	0.0%	10,332.7	0.1%
14.	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	8,834.0	0.1%	4,663.3	0.1%	22,735.6	0.3%
15.	Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	5,519.0	0.1%	4,066.0	0.1%	13,149.0	0.2%
16.	Боловсрол	17,972.7	0.4%	17,788.1	0.5%	40,746.5	0.5%
17.	Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	8,477.1	0.2%	10,335.4	0.3%	25,749.8	0.3%
18.	Урлаг, үзвэр, тоглоом наадам	3,026.6	0.1%	5,495.2	0.2%	17,826.4	0.2%
19.	Бусад	3,312,339.7	83.0%	2,886,919.4	82.7%	5,590,597.7	72.0%
<i>Иргэнд олгосон зээл</i>		3,660,563.5	90.4%	3,183,836.8	91.2%	6,861,263.5	88.3%
<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>		387,266.3	9.6%	307,614.6	8.8%	906,081.5	11.7%
НИЙТ		4,047,829.8	100%	3,491,451.3	100%	7,767,345.0	100%

Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “[Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал](#)”-аар нийт олгосон зээлийн 81.8% буюу 3.3 их наяд төгрөг нь бусад ангилалд (ихэвчлэн хэрэглээний зээл), 7.1% буюу 285.9 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 82.7% буюу 2.9 тэрбум төгрөг нь бусад ангиллын зээлээс, 6.4% буюу 224.1 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс төлөгджээ.

Тайлант улиралд олгосон зээлийг хугацааны ангиллаар харвал 1 сар хүртэлх хугацаатай олгосон зээл нийт зээлийн 22.9 хувийг, 1-3 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 14.2 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 17.5 хувийг, 1-5 жил хүртэлх хугацаатай олгосон зээл тус тус нийт зээлийн 32.7 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 6 Олгосон зээл (хугацааны ангиллаар)



Нийт зээлийн үлдэгдлийн ангиллаас харахад 7.8 их наяд төгрөгийн зээлийн 49.7 хувийг иргэний хэрэглээний зээлийн үлдэгдэл, үүнээс 17.2 хувийг автомашинд зориулсан зээлийн

үлдэгдэл, 32.5 хувийг хуулийн этгээдийн болон иргэнд олгосон бизнесийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Хүснэгт 16 Зээлийн ангилал (тэрбум төгрөгөөр)

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Иргэнд олгосон зээл	3,660.6	90.4%	3,183.8	91.2%	6,861.2	88.3%
Хэрэглээнд зориулсан зээл	2,257.1	55.8%	2,106.0	60.3%	3,862.9	49.7%
Үүнээс: Автомашинд зориулсан зээл	169.9	4.2%	222.8	6.4%	1,336.0	17.2%
Бизнес зориулсан зээл	683.4	16.9%	488.4	14.0%	1,743.4	22.4%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	44.9	1.1%	30.8	0.9%	183.2	2.4%
Бусад зээл	675.2	16.7%	558.7	16.0%	1,071.7	13.8%
Хуулийн этгээдэд олгосон зээл	387.3	9.6%	307.6	8.8%	906.1	11.7%
Бизнесийн зээл	297.7	7.4%	230.9	6.6%	783.6	10.1%
Автомашинны зээл	1.5	0.0%	2.4	0.1%	10.1	0.1%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	3.9	0.1%	5.0	0.1%	9.1	0.1%
Бусад зээл	84.1	2.1%	69.3	2.0%	103.3	1.3%
НИЙТ	4,047.8	100%	3,491.5	100%	7,767.3	100%

Цахим зээл


Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглан уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй финтек зээлийн үйлчилгээг 82 ББСБ 77 аппликэйшнээр дамжуулан олгож байна.

Хүснэгт 17 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр)

	Зээлийн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	5,123,924,779.1	66.0%	275,970	8.0%	18,567.0
Цахим зээл	2,643,420,268.8	34.0%	3,191,501	92.0%	828.3
Нийт	7,767,345,047.9	100%	3,467,471	100.00%	2,240.1

2026 оны I улирлын байдлаар ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 3.2 сая зээлдэгчийн 2.6 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 92.0 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 34.0 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 828.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 22.4 дахин бага байна.

Зураг 7 Сүүлийн 4 жилийн байдлаар финтек зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр)



Өмнөх оны мөн үеэс финтек зээлдэгчийн тоо 39.4 хувиар өсөн 3,191,501-т хүрч, зээлийн үлдэгдлийн хэмжээ 44.0% буюу 0.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Финтек зээлийн багцын 81.4 хувийг буюу 2.1 их наяд төгрөгийг хэвийн зээл, 6.9 хувийг буюу 181.7 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 11.7 хувийг буюу 309.3 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Цахим зээлийн мэдээлэл ирүүлээгүй 8 ББСБ-уудад холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байна.

Хүснэгт 18 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд (мянган төгрөгөөр)

№	Финтек	App нэр	Бүртгүүлсэн огноо
1	Покет	Pocket.mn	2023.05.08-№7/1871
2	Соно финтек	Sono Mongolia	2023.03.03-№7/895
3	Мобифинанс	Monpay	2023.06.20-№7/2540
4	Тус финтек	Tus fintech	2023.05.19-№7/2125
5	Анлок капитал	Unlock Finance	2024.04.23-№7/1442
6	Кэйш флов финанс	Tugrug App	2024.02.21-№7/632
7	Прогресс финтек	Zuut	2024.05.30-№7/2044
8	Таван богд финанс	PayOn.mn	2023.07.04-№7/2826
9	Лэндмн	LendMN	2023.06.20-№7/2550
10	Нөмөр кредит	Numur	2023.03.03-№7/890
11	ТОКИ	Toki	2023.06.20-№7/2549
12	Ашид капитал	Simple.mn	2023.11.10-№7/4317
13	Инвескор	InvesCore Pocket.mn	2023.08.25-№7/3350 2023.05.25
14	Нэг капитал финанс корпораци	NetPay	2023.07.04-№7/2825
15	Омни капитал	Moni	2023.07.05-№7/2869
16	Ардкредит	Ard	2023.12.22-№7/4873
17	Хатан суудал инвест	Zeely	2023.03.03-№7/894
18	Сэндли	Sendly	2023.07.04-№7/2821
19	Соломон инвестментс	M credit	2023.11.10-№7/4319
20	Үнэт кредит	Valu up M credit	2025.04.30-№3/1598 2024.12.05
21	Жи Эс Би Капитал	Prime SG Pay	2024.02.21-№7/631 2025.06.03-№3/2244
22	Си и си инвестмент	Pocket.mn M credit	2024.04.24 45800
23	Ньюстар финанс	Nsf.mn Lite+	2023.06.20-№7/2552 2023.06.20-№7/2553
24	Гэрэлфинанс	Gerel	2023.05.08-№7/1872
25	Номин юнити	OmniWay Nomin Unity	2024.02.21-№7/634 2024.04.23-№7/1443
26	Дэвжих нэхий	Money-T	2023.12.22-№7/4870
27	Зөгий санхүүгийн групп	Pocket.mn	7/21/2025
28	Очир ундраа ОМЗ	Opay MN	2023.08.25-№7/3351
29	Навитас фонд	Pocket.mn	2025.02.03
30	Мөнгөнзоос кредит	Pocket.mn	2023.05.24
31	Микрокредит	Easy	2023.12.22-№7/4871
32	Бизнес-Инвест девелопмент	BiD	2023.08.25-№7/3353
33	Цогзолфинанс	Pocket.mn	2023.05.23
34	Сатоши накамото	Cash24	2025.09.02-№7/3282
35	Сэнд эм эн	SendMN Pocket.mn	2024.02.21-№7/636 2023.12.20
36	Хас хаан	ХАСХААН	2023.06.20-№7/2551
37	Финруут-Инвестмент	Pocket.mn	2023.05.24
38	Сүн наяд	HiBro	2026.01.16-№7/142
39	Есөн финанс	MetaLend	2023.08.25-№7/3352
40	Мэйн стрит финанс	Pays	2025.02.11-№3/425
41	Энт кредит инвестмент	EntCreditMN	2023.03.03-№7/891
42	Грийн-Инвестмент	Gate.mn	2023.07.04-№7/2827
43	Балансэд кредит	Balance	2024.12.04-№7/3981
44	Алтан зоос капитал	ZOOS	2024.05.30-№7/2046
45	БСБ финанс	BSB Finance	2025.02.11-№3/427
46	Төвхөн ингүүмэл	Oneclick.mn	2024.07.09-№7/2534
47	Монголиан юнайтед кредит	UniPay.mn	2024.12.04-№7/3979
48	Финко капитал	Beep	2024.09.23-№7/3172
49	Авто зээл платформс	Valu up	2025.09.16
50	Их монгол кредит	Ikh Mongol Credit	2024.02.21-№7/633
51	Фингейт эм эн	M credit	7/3/2025
52	Инвеско фонд	IF.mn	2023.08.25-№7/3349
53	Изи пэй норбула	Easypay.mn	2023.12.22-№7/4867
54	Жи Би Си Си	E-zeel	2023.03.03-№7/889
55	Хексинг финанс	Sign Finance	2024.12.04-№7/3980
56	Централ капитал	Kmobimn	2024.04.23-№7/1441
57	Их ирээдүй капитал	Easy loan	2024.05.30-№7/2043
58	Девелопинг энтрепрениориал монголиа	DEM.mn	2024.05.30-№7/2045
59	Монголиа импакт финанс	Qmoni	2023.08.25-№7/3356
60	Гурван зуун жар файнанс	Minu plus	2023.07.04-№7/2822
61	Зээл Эм Эн платформ	Zeel.mn	2023.07.04-№7/2828
62	Вишнфанд	Вишнфанд	2024.12.04-№7/3982
63	Нанокапитал	Nano Capital	2023.07.04-№7/2824
64	Өсөх ундарга финанс	Ufinance	2024.09.23-№7/3171
65	Бэрс финанс	Bers Pay	2025.10.21-№7/3854
66	Хангууд финанс	Khanguud	2023.12.22-№7/4872
67	Тапапэй	Tapa	2024.09.24-№7/3174
68	Франкфурт капитал	Nar app	2023.07.04-№7/2823
69	Монкор финанс	Cash pay	2024.07.09-№7/2535
70	Улаанбаатар кредит	Upay	2024.12.16-№7/4110

71 Мандал дижитал кредит	Car zeel	2025.09.03.-№7/3308
72 Бичил глобус финанс	BG pay	2025.10.21-№7/3853
73 Эм Эл Жи капитал	ANDA	2024.07.09-№7/2536
74 Дарь финанс	Money mate Pocket.mn	2025.06.18-№7/2427 2024.03.01
75 Бүрэнфинанс	Buren zeel	2025.10.17-№7/3819
76 Гоулдман инвестмент групп	Goldpay	2023.08.25-№7/3355
77 Есөн эрдэнэ финанс	Leasing.mn	2023.03.30-№7/1298
78 Каббэй	UBCab Driver	2026.02.02-№7/339
79 ЛэндМН СМЭ	LendMN	7/28/2025
80 Магна профит энд инвестмент	Magna.mn	2024.02.21-№7/635
81 Монголын санхүүгийн групп	Мост мони	2024.12.25
82 Прогресскапитал	ProgressPay	2025.10.10-№7/3737

/"Инвекор ББСБ" ХК-ийн Pocket аппликэйшнд бүртгэлтэй 10 ББСБ байна. Зөвхөн аппликэйшнээр зээл олгож байгаа 7 ББСБ-ыг шараар тэмдэглэв/

Ногоон зээл

Тайлант хугацаанд 31 ББСБ 10,868 зээлдэгчид 42.1 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 2.8 хувийн хүүтэйгээр олгож, 41 ББСБ-ын 11,278 зээлдэгчээс 46.3 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2026 оны I улирлын байдлаар 48 ББСБ 16,757 зээлдэгчийн 132.8 тэрбум төгрөгийн “ногоон” зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 1.7%-тай тэнцэж байна.

Хүснэгт 19 Ногоон зээлийн тайлан (сая төгрөгөөр)


	НОГООН ТАКСОНОМИ ҮНДСЭН 12 АНГИЛАЛ	Олгосон зээлийн		Төлөгдсөн зээлийн		Зээлийн эцсийн үлдэгдлийн	
		Дүн	Зээлдэгч- дийн тоо	Дүн	Зээлдэгч- дийн тоо	Дүн	Зээлдэгч- дийн тоо
Ногоон	1. Эрчим хүчний хангамж, дэд бүтэц	7,305.2	6,990	7,055.8	5,748	10,352.0	7,438
	2. Эрчим хүчний үр ашиг	8,524.0	776	5,788.3	1,202	23,955.6	3,383
	3. Тогтвортой хот төлөвлөлт ба барилга	4,611.7	283	6,003.0	395	26,355.1	1,264
	4. Бохирдлыг бууруулах ба сэргийлэх	-	-	4.0	-	97.5	7
	5. Тогтвортой ус, хог хаягдал	156.5	44	421.0	32	636.3	49
	6. Тогтвортой хөдөө аж, ахуй	464.7	45	1,706.8	53	2,867.7	134
	7. Тогтвортой газар ашиглалт ба биологийн олон янз байдал	391.5	11	145.8	257	5,973.1	51
	8. Нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээвэр	16,413.8	384	17,483.1	1,185	40,831.3	1,620
	8.1.Цахилгаан тээврийн хэрэгсэл	681.6	13	6,366.0	91	2,790.6	139
	8.2.Хосолсон хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл	15,500.5	363	10,556.4	982	32,365.4	1,178
8.3.Хэмнэлттэй тээврийн хэрэгсэл	-	-	429.6	96	5,107.0	286	
8.4.Дугуй, скүүтер	8.7	4	102.8	4	8.4	6	
8.5.Бусад	223.0	4	28.2	12	559.9	11	
Нийгэм	9. Мэдээлэл, харилцаа холбоо, технологи	1,501.7	2,173	2,189.5	2,017	2,313.8	2,309
	10. Эрүүл мэнд	2,073.8	81	1,876.9	93	11,052.7	258
	11. Боловсрол, Соёл	541.0	69	3,358.8	274	4,948.5	219
	12. Хүртээмжтэй дэд бүтэц	102.5	12	278.6	22	3,348.2	25
	НИЙТ	42,086.4	10,868	46,311.7	11,278	132,877.2	16,757

Ногоон зээлийн үлдэгдлийн 30.7% буюу 40.8 тэрбум төгрөгийг нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээврийн салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 19.8% буюу 26.4 тэрбум төгрөгийг тогтвортой хот төлөвлөлт ба барилгын салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 18.1% буюу 24.1 тэрбум төгрөгийг эрчим хүчний үр ашиг салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 2.2% буюу 2.9 тэрбум төгрөгийг тогтвортой хөдөө аж, ахуй салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 8.3% буюу 11.1 тэрбум төгрөгийг эрүүл мэнд ангиллын салбарт олгосон зээлийн үлдэгдэл, болон 20.9% буюу 27.6 тэрбум төгрөгийг бусад ангиллын салбарт олгосон зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2022 оны 03 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулсан “Ногоон санхүүжилт – Бүс нутгийн чуулган”-аар уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах чиглэлээр бүс нутгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тогтвортой, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх, “Ногоон хөгжлийн сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх талаар хэлэлцэн, зөвлөмж гаргасан. Зөвлөмжийн 1 дүгээр бүлгийн 1.3-т “Ногоон зээлийг банкны салбарт 10 хувь, ББСБ-уудад 5 хувьд хүргэхэд шаардлагатай бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ногоон зээлд эрсдэлийн сан байгуулах, хөнгөлөлт урамшуулал олгох, ногоон


зээлийн эх үүсвэрийн свопын зардлыг бууруулах зэрэг хөшүүрэг бий болгох” үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хүлээсэн. Үүний дагуу 2022 оны I дүгээр улирлаас эхлэн “Монгол Улсын Ногоон таксономи”-ийн үндсэн ангиллын дагуу ББСБ-уудаас “Ногоон зээлийн тайлан”-г авч эхэлсэн. 2022 оны I улирлын байдлаар 41.6 сая төгрөгийн ногоон зээлийн үлдэгдэлтэй байсан бол, 2026 оны мөн улиралд ногоон зээлийн үлдэгдэл 1.2 дахин өсч 132.9 тэрбум төгрөгийн ногоон зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Зураг 8 Сүүлийн 3 жилийн байдлаар ногоон зээлийн үлдэгдэл(тэрбум төгрөгөөр)



Нийт зээлийн үлдэгдлийн 88.9% буюу 118.1 тэрбум төгрөг нь хэвийн, 4.0% буюу 5.2 тэрбум төгрөг нь анхаарал хандуулах, 7.1% буюу 9.5 тэрбум төгрөг нь чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Зураг 9 Ногоон зээлийн багцын чанар (ногоон таксономийн 12 ангиллаар)



Факторингийн тооцооны авлага

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 106.6 хувиар буюу 59.0 тэрбум төгрөгөөр өсөж, 28 ББСБ 114.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ (“Стор пэй” ХХК нь СЗХ-ны 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн №637 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авч салбарын факторингийн тооцооны авлага өссөн). 2026 оны I улирлын байдлаар 688.8 сая төгрөгийн факторингийн тооцооны хүүгийн авлага хуримтлуулан бүртгэсэн байна. Нийт 24.5 тэрбум төгрөгийн анхаарал хандуулах болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 10.5 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 103.8 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 20 Факторингийн тооцооны авлагын ангилал (сая төгрөгөөр)

Нийт факторингийн тооцооны авлага	2025-I		2026-I		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Нийт дүн	Эзлэх хувь	
Хэвийн	55,374.0	100.0%	114,376.4	100%	59,002.4	106.6%
Анхаарал хандуулах	45,277.2	81.8%	89,139.1	77.9%	43,861.9	96.9%
Чанаргүй	2,850.3	5.1%	6,955.8	6.1%	4,105.5	144.0%
Хэвийн бус	6,100.2	11.0%	17,592.7	15.4%	11,492.5	188.4%
Эргэлзээтэй	2,401.5	4.3%	4,939.4	4.3%	2,537.9	105.7%
Муу	2,300.2	4.2%	7,386.6	6.5%	5,086.4	221.1%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	1,398.5	2.5%	5,266.7	4.6%	3,868.1	276.6%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	3,446.5	6.2%	10,542.6	9.2%	7,096.2	205.9%
Факторингийн тооцооны хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,146.2	2.1%	688.8	0.6%	-457.5	-39.9%

Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн ба факторингийн тусгай зөвшөөрөлтэй 61 ББСБ-уудаас 31 ББСБ нь тайлант хугацаанд факторингийн үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Үүсмэл санхүүгийн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө

2026 оны I улирлын байдлаар 4 ББСБ 3.2 тэрбум төгрөгийн своп арилжаа хийсэн байна. Бусад санхүүгийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 54.7 хувь буюу 83.2 тэрбум төгрөгөөр өсөж 235.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 21 Бусад хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл-тэй	Уламж-лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	3,199.8	3,199.8	2,310.2	889.6	-	3,199.8	-	889.6	59.1
Свop арилжаа	3,187.9	3,187.9	2,298.3	889.6	-	3,187.9	-	889.6	59.1
Бусад арилжаа	11.9	11.9	11.9	-	-	11.9	-	-	-
Бусад санхүүгийн хөрөнгө	235,175.7	140,492.3	85,757.4	149,418.3	3,041.5	229,883.0	5,292.7	43,765.6	19,776.2
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны авлага	22,309.5	22,309.5	-	22,309.5	-	22,309.5	-	-	-
Авлага(цэвэр дүнгээр)	188,355.6	107,057.2	74,201.1	114,154.6	3,041.5	183,574.5	4,781.1	41,880.6	17,637.9
Салбар хоорондын тооцоо	5,413.6	5,171.2	133.1	5,280.5	-	5,303.6	110.0	-	-
Өмчлөх бусад хөрөнгө – санхүүгийн хөрөнгө (цэвэр дүнгээр)	7,739.8	277.5	7,645.8	94.0	-	7,339.8	400.0	-	260.4
Бусад	11,357.1	5,676.9	3,777.4	7,579.8	-	11,355.5	1.6	1,885.0	1,877.9

Санхүүгийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2026 оны I улирлын байдлаар 251.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 72.1 тэрбум төгрөгийн элэгдэл байгуулж, 1.4 сая төгрөгийн үнэ цэнийн бууралтыг бүртгэсэн байгаа бол 106.6 тэрбум төгрөгийн биет бус хөрөнгийн үлдэгдэлд 39.3 тэрбум төгрөгийн хорогдол байгуулсан байна.

Ингэснээр тайлант хугацаанд 179.1 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 66.7 тэрбум төгрөгийн биет бус хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 22 Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)

Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгө	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
	245,842.6	164,123.2	78,072.9	167,769.7	721.3	241,476.4	4,366.2	21,799.9	17,951.9
Үндсэн хөрөнгө (цэврээр)	179,144.3	119,605.1	62,757.0	116,387.3	718.6	175,031.0	4,113.2	11,644.7	13,274.6
Барилга, байгууламж	90,846.8	66,041.4	24,988.1	65,858.6	79.5	88,872.0	1,974.8	5,148.2	7,467.7
Компьютер, дагалдах хэрэгсэл	13,316.6	9,811.2	3,984.6	9,331.9	38.8	12,836.2	480.4	1,053.1	853.0
Тээврийн хэрэгсэл	42,793.9	18,960.1	25,822.5	16,971.4	488.7	41,660.9	1,133.0	1,627.4	2,092.7
Тавилга, эд хогшил	20,080.5	13,947.0	7,049.5	13,031.0	105.7	19,568.5	512.0	1,853.8	1,947.2
Түрээсийн хөрөнгө	6,957.3	6,900.3	112.1	6,845.2	-	6,948.6	8.7	225.1	9.2
Борлуулаад буцаан түрээсэлсэн хөрөнгө	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	5,149.2	3,945.1	800.1	4,349.2	5.9	5,144.8	4.4	1,737.1	904.9
Биет бус хөрөнгө (цэврээр)	66,698.3	44,518.2	15,315.9	51,382.4	2.7	66,445.3	253.0	10,155.2	4,677.3
Зохиогчийн эрх	23.9	-	23.9	-	-	4.9	19.0	-	-
Програм хайгамж	34,208.2	29,184.0	2,992.6	31,215.6	2.3	33,998.2	210.0	5,031.3	2,623.3
Мэдээллийн сан	12.0	12.0	-	12.0	-	12.0	-	12.0	-
Патент	6,237.2	0.7	7.3	6,229.9	-	6,237.2	-	-	-
Барааны тэмдэг	42.1	17.6	-	42.1	-	42.1	-	-	-
Тусгай зөвшөөрөл	17.8	-	-	17.8	-	17.8	-	-	-
Газар эзэмших эрх	2,901.9	2,765.3	136.5	2,765.3	-	2,890.3	11.5	-	-
Ашиглах эрхтэй хөрөнгө	12,652.4	11,004.4	2,828.9	9,823.5	-	12,640.4	12.0	4,391.8	2,052.5
Бусад биет бус хөрөнгө	10,602.8	1,534.2	9,326.6	1,276.2	0.3	10,602.4	0.5	720.1	1.5

Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар буюу 2.0 их наяд төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 37.6 хувийг өр төлбөрийн өсөлт, 62.4 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 23 Пассивын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр)


Пассивын үзүүлэлтүүд	2025-I	Нийт дүнд эзлэх хувь	2026-I	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
	дүн		дүн		дүн	хувь
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,683,673.8	48.7%	4,435,792.7	46.4%	752,118.9	20.4%
САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,471,985.8	45.9%	4,200,196.0	43.9%	728,210.2	21.0%
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	1,196,091.2	15.8%	1,585,533.8	16.6%	389,442.6	32.6%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	1,423,847.7	18.8%	1,480,481.4	15.5%	56,633.7	4.0%
Бусад эх үүсвэр	702,909.8	9.3%	712,777.7	7.4%	9,867.9	1.4%
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	4,147.6	0.1%	2,101.7	0.0%	-2,045.9	-49.3%
Бусад санхүүгийн өр төлбөр	142,747.3	1.9%	331,863.9	3.5%	189,116.5	132.5%
Хоёрдогч өглөг	2,242.2	0.0%	86,116.2	0.9%	83,874.0	3740.7%
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	0.0%	132.1	0.0%	132.1	0.0%
САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	211,688.1	2.8%	235,596.7	2.5%	23,908.7	11.3%
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,884,712.5	51.3%	5,135,065.8	53.6%	1,250,353.3	32.2%
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,820,558.2	24.1%	2,333,836.3	24.4%	513,278.1	28.2%
Нэмж төлөгдсөн капитал	87,549.5	1.2%	108,984.4	1.1%	21,435.0	24.5%
Халаасны хувьцаа	(2,580.2)	-	(2,580.2)	-	-	0.0%
Үндсэн хөрөнгө, биет бус ХДҮН	17,109.7	0.2%	22,814.3	0.2%	5,704.6	33.3%
Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,859,122.5	24.6%	2,517,627.5	26.3%	658,505.0	35.4%
Бусад өмч	102,952.8	1.4%	154,383.4	1.6%	51,430.6	50.0%
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,568,386.4	100%	9,570,858.5	100%	2,002,472.2	26.5%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 1.3 дахин, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 1.0 дахин, бусад эх үүсвэр 1.0 дахин, үүсмэл санхүүгийн өр төлбөр 0.5 дахин, бусад санхүүгийн өр төлбөр 2.3 дахин,

барагдуулах ёстой хоёрдогч өглөгийн өр төлбөр 38.4 дахин өссөн бол өөрийн хөрөнгөөс хуримтлагдсан ашиг 35.4 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 28.2 хувиар, нэмж төлөгдсөн капитал 24.5 хувиар тус тус өссөн байна.


Салбарын сүүлийн 5 жилийн байдлаарх санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг банкны салбартай харьцуулбал 2021 оны I улирлын байдлаар өөрийн хөрөнгө банкны салбарын 47.0 хувьд хүрдэг байсан бол 2026 оны I улирлын байдлаар 65.0 хувьд хүрч байна. 2026 оны I улирлын байдлаар 578 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн 128.7 хувьтай тэнцэж байна. Хуримтлагдсан ашгийн хувьд өмнөх оны мөн үед 40.5 хувьтай тэнцдэг байсан бол 2026 оны I улирлын байдлаар 9.2 пунктээр өсөж 49.7 хувьтай тэнцэж байна.

Зураг 10 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг)



Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал 2026 оны I улирлын байдлаар салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2021 онтой харьцуулахад 3.5 дахин өсөж 5.1 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 7.3 дахин өсөж 4.4 их наяд төгрөгт хүрсэн байна.


Зураг 11 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Итгэлцлийн үйлчилгээний өглөг

2026 оны I улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээний өглөг өмнөх оны мөн үеэс 1.3 дахин буюу 389.4 тэрбум төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 92 ББСБ-аас 90 ББСБ итгэлцэл татан төвлөрүүлсэн ба үүнээс тусгай зөвшөөрөлгүй 1 ББСБ байгаа ба тухайн ББСБ-уудын итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл өмнөх улиралд хүчингүй болсон байна. Тайлант хугацаанд 16,941 итгэмжлэгчээс 1,585.5 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Зураг 12 Итгэлцлийн үйлчилгээний өглөг (тэрбум төгрөгөөр)



Нийт татан төвлөрүүлсэн итгэлцлийн өглөгийн 69.7 хувийг иргэдээс, 25.3 хувийг хувийн байгууллагаас, 0.3 хувийг эдийн засгийн харьяат бус этгээдээс татан төвлөрүүлсэн байна.

2026 оны I улирлын байдлаар 1,511.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж үүнд 74.8 тэрбум төгрөгийн үр шим хуримтлуулан тооцож бүртгэсэн байна.

Хүснэгт 24 Итгэлцлийн үйлчилгээ (сая төгрөгөөр)

	Дүн	Хувь	Итгэл-цэлтэй	Уламж-лалт	Финтек	УБ	ХОН	ХК	ГХО
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	1,585,533.8	100.0%	1,584,715.9	173,398.1	1,412,135.7	1,581,723.3	3,810.5	288,493.1	167,916.2
Хувийн байгууллага	400,922.7	25.3%	400,922.7	57,683.9	343,238.8	399,718.9	1,203.8	59,336.0	51,581.8
Иргэд	1,104,915.1	69.7%	1,104,125.1	107,970.9	996,944.1	1,102,506.0	2,409.0	213,456.0	100,039.3
Өрх гэр, иргэдэд үйлчлэгч ашгийн бус байгууллага (Улс төрийн нам, сүм хийд)	-	0.0%	-	-	-	-	-	-	-
Эдийн засгийн харьяат бус	5,412.8	0.3%	5,412.8	-	5,412.8	5,412.8	-	-	5,412.8
Итгэлцлээр татсан хөрөнгөнд хуримтлуулаж тооцсон үр шим	74,797.5	4.7%	74,769.6	7,743.3	67,054.2	74,599.8	197.7	16,093.6	10,882.4
Итгэлцлээр татсан хөрөнгийн хойшлогдсон төлбөр	514.2	0.0%	514.2	-	514.2	514.2	-	392.5	-
Нийт итгэмжлэгчдийн тоо	16,941		16,939	804	16,137	-	16,893	48	7,154

Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр

2026 оны I улирлын байдлаар дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.0 дахин өсөж, 109 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 1,480.5 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 25 Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл- тэй	Уламж- лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	1,480,481.4	1,345,596.4	254,879.8	1,225,601.6	233.0	1,479,187.4	1,294.0	552,572.8	343,174.7
Авсан зээл	1,427,684.8	1,300,467.4	233,282.5	1,194,402.3	-	1,426,392.6	1,292.2	539,985.8	321,646.8
Дотоодын	368,693.6	293,097.1	38,688.2	330,005.4	-	367,651.4	1,042.2	131,517.3	118,470.4
Гадаадын	791,931.6	785,636.7	126,461.5	665,470.1	-	791,931.6	-	378,219.8	203,176.4
Бусад	267,263.2	221,937.3	68,132.8	199,130.4	-	267,013.2	250.0	30,248.7	-
Бодит үнэ цэнийн залруулга	203.6	203.6	-	203.6	-	203.6	-	-	-
Хугацаа хэтрэлт	16,886.3	16,124.8	16,357.8	528.5	233.0	16,886.3	-	-	16,124.8
Дотоодын	761.5	-	233.0	528.5	233.0	761.5	-	-	-
Гадаадын	16,124.8	16,124.8	16,124.8	-	-	16,124.8	-	-	16,124.8
Бусад	-	-	-	-	-	-	-	-	-
Бодит үнэ цэнийн залруулга	3,727.8	3,727.8	-	3,727.8	-	3,727.8	-	2,978.6	1,679.0
Дотоодын	6.7	6.7	-	6.7	-	6.7	-	6.7	-
Гадаадын	3,721.2	3,721.2	-	3,721.2	-	3,721.2	-	2,971.9	1,679.0
Бусад	-	-	-	-	-	-	-	-	-
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	39,638.1	32,732.0	5,239.5	34,398.7	-	39,636.4	1.7	15,565.5	7,082.1
Дотоодын	10,567.1	3,930.8	233.2	10,334.0	-	10,565.4	1.7	767.0	681.1
Гадаадын	19,854.6	19,749.7	4,512.6	15,341.9	-	19,854.6	-	8,060.8	6,401.0
Бусад	9,216.4	9,051.5	493.7	8,722.8	-	9,216.4	-	6,737.7	-

Бусад эх үүсвэр

2026 оны I улирлын байдлаар 84 ББСБ 712.8 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ. Үүнээс давхардсан тоогоор 69 ББСБ 597.1 тэрбум төгрөгийн өрийн бичиг, 4 ББСБ 76.5 тэрбум төгрөгийн үнэт цаас, 4 ББСБ төслийн зээл, 24 ББСБ 16.0 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэр, 7 ББСБ 1.2 тэрбум төгрөгийн хойшлогдсон төлбөр, 67 ББСБ 18.0 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 26 Бусад эх үүсвэрийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл- тэй	Уламж- лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Бусад эх үүсвэр	712,777.7	643,300.7	93,110.5	619,667.3	-	712,687.7	90.0	82,678.9	42,653.1
Гаргасан өрийн бичиг	597,110.3	532,653.4	68,803.6	528,306.7	-	597,110.3	-	76,711.6	38,000.0
Гаргасан үнэт цаас	76,536.5	76,536.5	19,100.0	57,436.5	-	76,536.5	-	-	1,600.0
Төслийн зээлийн санхүүжилт	6,314.5	6,248.6	101.6	6,212.8	-	6,314.5	-	-	-
Бусад	15,982.8	15,085.0	1,817.1	14,165.7	-	15,892.8	90.0	4,997.0	2,366.6
Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	1,186.6	1,052.7	267.2	919.4	-	1,186.6	-	404.8	203.9
Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	18,020.2	13,829.9	3,555.2	14,465.0	-	18,020.2	-	1,375.1	890.5

ББСБ-аас гаргасан өрийн бичиг


ББСБ-ууд өрийн бичиг гаргахдаа “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах үүрэгтэй.

2026 оны I улирлын байдлаар биржийн бус зах зээл дээр 69 ББСБ 597.1 сая төгрөг татан төвлөрүүлсэн тухай тоо мэдээ ирүүлсэн байна.

Биржийн зах зээл дээр 2026 оны I улирлын байдлаар 3 ББСБ 33.5 тэрбум төгрөгийг бондыг татан төвлөрүүлсэн байна.

69 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд 597.1 тэрбум төгрөгийн өрийн бичгийн үлдэгдэлтэй гарсан байгаа нь 2021 оны мөн үеэс 8.5 дахин өссөн үзүүлэлт юм.


Зураг 13 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 4 ББСБ 6.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Төслийн зээлийн санхүүжилт 2021 оны мөн үеэс 14.2 тэрбум төгрөг буюу 3.2 дахин, өмнөх оны мөн үеэс 41.6 тэрбум төгрөг буюу 7.6 дахин буурсан байна.

Зураг 14 Төслийн зээлийн санхүүжилт сүүлийн 5 жилийн байдлаар



Төслийн зээлийн санхүүжилтийг олгосон субъектээр нь ангилж харвал 0.6 хувь нь засгийн газрын санхүүжилттэй, 1.0 хувь нь гадаадын төслийн, 98.4 хувь нь бусад санхүүжилттэй төслийн санхүүжилтийн зээл бүрдүүлж байна.

Хүснэгт 27 Төслийн зээл санхүүжилт (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Төслийн зээлийн санхүүжилт	6,314.5	6,248.6	101.6	6,212.8	-	6,314.5	-	-	-
Засгийн газрын санхүүжилттэй	35.8	35.8	35.8	-	-	35.8	-	-	-
Гадаадын санхүүжилттэй	65.9	-	65.9	-	-	65.9	-	-	-
Дотоодын санхүүжилттэй	1.1	1.1	-	1.1	-	1.1	-	-	-
Жижиг дунд үйлдвэрлэлийн төслийн санхүүжилтийн зээл	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад	6,211.8	6,211.8	-	6,211.8	-	6,211.8	-	-	-
Зах зээлийн хүүгийн түвшнээс өндөр буюу бага хүү бүхий зээлийн бодит үнэ цэнийн тохируулга	-	-	-	-	-	-	-	-	-

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)

2026 оны I улирлын байдлаар ББСБ-уудын гаргасан ХБҮЦ-ыг харвал 18-24 сарын хугацаатай, жилийн 17.0-20.0 хувийн хүүтэй, 6.0-50.0 тэрбум төгрөгийн буюу нийт 323.0 тэрбум төгрөгийн 10 ББСБ-ийн нээлттэй зах зээлд гаргасан ХБҮЦ байна.

Бусад санхүүгийн өр төлбөр

2026 оны I улирлын байдлаар 5 ББСБ 2.1 тэрбум төгрөгийн үүсмэл санхүүгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй, 142 ББСБ 331.9 тэрбум төгрөгийн бусад санхүүгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй, 10 ББСБ 86.1 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 28 Бусад өр төлбөр (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	2,101.7	1,197.7	1,081.5	1,020.2	119.8	2,101.7	-	1,020.2	748.0
Форвард арилжаа	784.2	-	784.2	-	-	784.2	-	-	-
Своп арилжаа	1,197.7	1,197.7	177.5	1,020.2	-	1,197.7	-	1,020.2	748.0
Опшин арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Фьючерс арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад арилжаа	119.8	-	119.8	-	119.8	119.8	-	-	-
Бусад санхүүгийн өр төлбөр	331,863.9	240,326.3	70,247.9	261,616.0	856.2	327,655.8	4,208.1	72,684.2	62,472.3
Хоёрдогч өглөг	86,116.2	2,290.5	419.3	85,697.0	-	85,916.2	200.0	368.6	-
						2	0		
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	1,321.3	1,321.3	-	1,321.3	-	1,321.3	-	-	-

Санхүүгийн бус өр төлбөр

Санхүүгийн бус өр төлбөрийн 60.4 хувийг бусад өр төлбөр, 17.4 хувийг тайлант үеийн орлогын албан татварын өглөг, 15.6 хувийг бусад татварын өглөг, 1.3 хувийг урьдчилж орсон орлого, 2.1 хувийг цалингийн өглөг, 3.2 хувийг бусад өглөг бүрдүүлж байна.

Хүснэгт 29 Санхүүгийн бус өр төлбөр (сая төгрөгөөр)

САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
	235,596.7	148,895.3	95,056.6	140,540.1	448.8	231,313.5	4,283.2	20,095.7	10,998.0
Цалингийн өглөг	5,015.8	3,833.8	934.9	4,080.8	48.4	4,954.9	60.8	589.4	709.7
ЭМ, НДШ-ийн өглөг	2,986.7	1,630.9	917.8	2,068.9	31.4	2,883.8	102.9	21.1	174.2
Тайлант үеийн орлогын албан татварын өглөг	40,969.7	30,195.4	8,918.8	32,050.8	114.3	40,575.7	394.0	3,718.4	836.2
Бусад татварын өглөг	36,645.9	28,417.5	10,546.7	26,099.2	249.7	36,290.8	355.1	3,364.8	1,631.1
Хойшлогдсон татварын өглөг	2,429.5	1,956.0	1,282.9	1,146.7	-	2,348.8	80.7	416.5	481.8
Хойшлогдсон орлого	2,151.8	2,057.0	1,580.2	571.6	-	2,074.0	77.7	-	40.9
Урьдчилж орсон орлого	3,037.0	1,787.8	998.3	2,038.6	-	3,030.3	6.7	279.2	171.7
Борлуулах зорилгоор эзэмшиж буй өр төлбөр	87.3	-	87.3	-	-	87.3	-	-	-
Бусад	142,234.4	78,978.6	69,751.5	72,482.9	5.0	139,029.2	3,205.1	11,706.3	6,952.4
Нөөц, болзошгүй өр төлбөр	38.7	38.2	38.2	0.5	-	38.7	-	-	-

Өөрийн хөрөнгө

ББСБ-уудын өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 32.2 хувиар буюу 1,250.4 тэрбум төгрөгөөр өсөж 5.1 их наяд төгрөгт хүрсэн нь нийт активын 53.6 хувийг бүрдүүлж байна. ББСБ-уудын өөрийн хөрөнгийн 45.4 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 49.0 хувийг хуримтлагдсан ашиг, 5.6 хувийг өөрийн хөрөнгийн бусад хэсэг бүрдүүлж байна.

Хүснэгт 30 Өөрийн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Хувь нийлүүлсэн хөрөнгө	2,333.8	1,069.8	1,353.4	980.5	29.5	2,250.8	83.0	59.3	149.4
Нэмж төлөгдсөн капитал	109.0	107.9	18.9	90.1	0.0	108.8	0.2	68.6	48.9
Халаасны хувьцаа	2.6	2.6	0.2	2.4	-	2.6	-	2.4	0.0
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22.8	15.3	0.2	22.6	-	22.7	0.1	-	0.0
Хуримтлагдсан ашиг, алдагдал	2,517.6	1,883.1	826.4	1,691.2	12.9	2,471.8	45.8	301.0	189.3
Бусад өмч	154.4	145.3	14.5	139.9	-	153.2	1.2	38.2	7.5
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,135.1	3,218.9	2,213.2	2,921.8	42.4	5,004.7	130.4	464.6	395.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,570.9	7,186.5	2,901.4	6,669.4	44.1	9,426.6	144.3	1,482.6	1,023.1
Нийт хөрөнгөд эзлэх хувь	0.5	0.4	0.8	0.4	1.0	0.5	0.9	0.3	0.4

Хувь нийлүүлсэн хөрөнгө


Хувь нийлүүлсэн хөрөнгө нь өмнөх оны мөн үеэс 28.2 хувь буюу 513.3 тэрбум төгрөгөөр өсөж 2.3 их наяд төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 31 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Хувь нийлүүлсэн хөрөнгө	2,333,836.3	1,069,847.2	1,353,366.5	980,469.8	29,477.4	2,250,798.2	83,038.2	59,266.7	149,354.0
Давуу эрхийн хувьцаа (өөрийн хөрөнгө)	178,028.1	177,352.1	676.0	177,352.1	-	177,988.1	40.0	11,831.0	11,952.0
Энгийн хувьцаа - Хаалттай	2,108,372.6	845,059.4	1,346,650.5	761,722.0	29,477.4	2,025,374.4	82,998.2	-	114,168.0
Энгийн хувьцаа - Нээлттэй	47,435.7	47,435.7	6,040.0	41,395.7	-	47,435.7	-	47,435.7	23,234.0
Хоёрдогч өглөг (өөрийн хөрөнгө)	98,034.4	94,704.4	3,130.0	94,904.4	-	98,034.4	-	29,999.4	-
Хөрвөх өр төлбөр (өөрийн хөрөнгө)	-	-	-	-	-	-	-	-	-
Нэмж төлөгдсөн капитал	108,984.4	107,900.0	18,921.2	90,063.2	7.4	108,788.8	195.7	68,591.4	48,941.1
Давуу эрхийн хувьцаа	185.4	-	185.4	-	-	64.0	121.4	-	-
Энгийн хувьцаа	108,799.0	107,900.0	18,735.8	90,063.2	7.4	108,724.7	74.3	68,591.4	48,941.1
Халаасны хувьцаа	2,580.2	2,580.2	210.4	2,369.8	-	2,580.2	-	2,373.3	3.6
Давуу эрхийн хувьцаа	-	-	-	-	-	-	-	-	-
Энгийн хувьцаа	2,580.2	2,580.2	210.4	2,369.8	-	2,580.2	-	2,373.3	3.6

2026 оны I улирлын байдлаар 578 ББСБ-ын 2.2 их наяд төгрөгийн энгийн хувьцаа, 10 ББСБ-ын 178.0 тэрбум төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 4 ББСБ-ын 2.6 тэрбум төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна.

Зураг 15 Хувьцаат капитал сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын өөрийн хөрөнгийн хэмжээ 2.3 их наяд төгрөг байгаа нь нийт өөрийн хөрөнгийн 43.8 хувийг, бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн дүн 2.9 их наяд төгрөг байгаа нь нийт дүнгийн 78.9 хувийг бүрдүүлж байна. ББСБ-уудын үйл ажиллагаа өргөжиж, томрохын хэрээр бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлэх боломж нь нэмэгдэж байгаа тул эдгээр ББСБ-уудын зайны болон газар дээрх хяналт шалгалтыг сайжруулах шаардлагатай байна.

Хүснэгт 32 ХНХ-ийн интервал (тэрбум төгрөгөөр)

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	1,342.6	116	57.5%	20.1%	7.3	1	8.6	1	0.0	0
2.5-5.0 тэрбум	920.4	313	39.4%	54.2%	6.9	2	13.8	5	5.1	2
1.9-2.5 тэрбум	3.9	2	0.2%	0.3%	0.0	0	2.0	1	1.9	1
1.4-1.9 тэрбум	8.8	6	0.4%	1.0%	3.2	2	4.3	3	1.4	1
0.6-1.4 тэрбум	24.7	27	1.1%	4.7%	11.3	13	9.3	10	3.1	3
0.6 тэрбум хүртэлх	33.3	114	1.4%	19.7%	0.0	0	16.5	62	18.0	57
НИЙТ	2,333.8	578	100.0%	100.0%	28.6	18	54.4	82	29.5	64

2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 429 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 97.0% буюу 2.3 их наяд

төгрөг байна. Харин 2.5 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 149 ББСБ-ын 70.8 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.0 хувийг бүрдүүлж байна.

Өөрийн хөрөнгийн бусад хэсэг

2026 оны I улирлын байдлаар 33 ББСБ 22.8 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, 111 ББСБ 154.4 тэрбум төгрөгийн бусад өмчийн үлдэгдэлтэй гарчээ.


Хүснэгт 33 Бусад өмч, сангуудын бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22,814.3	15,314.7	233.5	22,580.8	-	22,674.4	139.9	-	6.5
Бусад өмч	154,383.4	145,278.5	14,460.9	139,922.5	-	153,198.2	1,185.2	38,195.1	7,485.4

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 35.4% буюу 658.5 тэрбум төгрөгөөр өсөж 2.5 их наяд төгрөгт хүрчээ.


Зураг 16 Хуримтлагдсан ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд 480 ББСБ нийт 276.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 10 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 88 ББСБ 4.4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Алдагдалтай ажилласан 88 ББСБ дотор эх үүсвэр татан төвлөрүүлсэн 14 ББСБ байна. Эдгээрийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг яаралтай хийж гүйцэтгэх шаардлагатай.


Зураг 17 Тайлант үеийн ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр)



Ашигт ажиллагаа

2026 оны I улирлын байдлаар ББСБ-ууд 772.1 тэрбум төгрөгийн орлого олж, 500.2 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 271.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 18 Ашигт ажиллагааны үзүүлэлт (тэрбум төгрөгөөр)



Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 28.0% буюу 168.7 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 34.7% буюу 128.9 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 17.1% буюу 39.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 34 Орлого, үр дүнгийн тайлан (харьцуулсан, сая төгрөгөөр)

Орлого, зардлын зүйл	2025-I	2026-I	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
НИЙТ ОРЛОГО	603,405.7	772,071.0	100.0%	168,665.4	603,405.7
Хүүгийн орлого	539,729.0	661,507.4	85.7%	121,778.4	539,729.0
Хүүгийн бус орлого	52,369.5	77,405.5	10.0%	25,036.1	52,369.5
Бусад орлого, олз	11,274.7	32,912.7	4.3%	21,638.0	11,274.7
Бусад дэлгэрэнгүй орлого	32.6	245.4	0.0%	212.8	32.6
НИЙТ ЗАРДАЛ	371,285.3	500,171.5	100.0%	128,886.3	371,285.3
Хүүгийн зардал	140,717.7	171,661.2	34.3%	30,943.5	140,717.7
Хүүгийн бус зардал	127,235.8	161,978.2	32.4%	34,742.3	127,235.8
Эрсдэлийн сангийн зардал	62,637.0	123,243.8	24.6%	60,606.7	62,637.0
Бусад зардал, гарз	5,112.9	6,497.9	1.3%	1,385.0	5,112.9
Орлогын албан татварын зардал	35,581.8	36,790.6	7.4%	1,208.8	35,581.8
ЦЭВЭР АШИГ	232,120.4	271,899.5		39,779.1	232,120.4

Нийт орлогын 85.7 хувийг хүүгийн орлого, нийт зардлын 34.3 хувийг хүүгийн зардал, 32.4 хувийг хүүгийн бус зардал бүрдүүлж байна. Хүүгийн бус зардлын 89.9 хувийг үйл ажиллагааны бусад зардал бүрдүүлж байгаа бөгөөд үүний 47.8 хувийг ажилтнуудын цалинтай холбоотой зардал бүрдүүлж байна.

Хүснэгт 35 Орлого, үр дүнгийн тайлан (тэр төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
НИЙТ ОРЛОГО	772.1	604.6	188.7	583.3	2.8	761.0	11.1	116.4	69.8
Хүүгийн орлого	661.5	533.2	152.4	509.1	0.1	651.6	9.9	97.9	55.7
Хүүгийн бус орлого	77.4	42.1	28.9	48.5	2.7	76.3	1.1	8.2	4.5
Бусад орлого, олз	32.9	29.2	7.3	25.6	0.0	32.8	0.1	10.3	9.6
Бусад дэлгэрэнгүй орлого	0.2	0.1	0.2	0.1	-	0.2	0.0	-	-
НИЙТ ЗАРДАЛ	500.2	406.0	106.5	393.6	1.9	494.2	6.0	91.3	54.1
Хүүгийн зардал	171.7	158.0	23.7	148.0	0.0	171.2	0.5	37.1	19.7
Хүүгийн бус зардал	162.0	111.3	47.6	114.4	1.8	158.2	3.8	20.9	13.4
Арилжааны зардал	1.9	1.6	0.4	1.6	0.1	1.9	-	0.2	0.1
Хани, үнэлгээний тэгшитгэлийн зардал	5.5	4.8	0.7	4.8	0.3	5.5	0.0	2.5	0.7
Хураамж, шимтгэлийн зардал	8.9	7.1	1.2	7.8	0.3	8.9	0.0	2.8	2.0
Үйл ажиллагааны бусад зардал	145.6	97.8	45.3	100.3	1.1	141.8	3.8	15.4	10.7
Эрсдэлийн сангийн зардал	123.2	103.1	25.6	97.6	-	121.9	1.4	28.5	17.9
Бусад зардал, гарз	6.5	3.1	3.6	2.9	0.0	6.4	0.1	0.6	1.2
ОАТ-ын зардал	36.8	30.5	6.1	30.7	0.1	36.6	0.2	4.2	2.0
НИЙТ ЦЭВЭР ОРЛОГО	271.9	198.6	82.2	189.7	0.9	266.7	5.2	25.0	15.7

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2026 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 578 ББСБ-ын 86.9% буюу 502 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 13.1% нь буюу 76 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 64 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 11 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

Хүснэгт 36 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд (үзүүлэлт бүрээр)

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэлцэл /92 ББСБ/		Итгэлцэл, ГВА-аас бусад /422 ББСБ/		ЗГВА /64 ББСБ/		Нийт /578 ББСБ/			
		√	X	√	X	√	X	√	X		
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	92	-	421	1	64	-	577	1		
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	92	-	420	2	64	-	576	2		
3.	Өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	92	-	422	-	64	-	578	-		
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	87	5	407	15	64	-	558	20		
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу)	87	5	400	22	64	-	550	28		
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	92	-	416	6	XXX		572	6		
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	92	-	422	-			578	-		
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	92	-	420	2			576	2		
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	91	1	419	3			574	4		
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	92	-	422	-			578	-		
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	91	1	422	-			577	1		
12.	Монголын хөрөнгийн биржийн “Г”, “Ш” ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	92	-	421	1			577	1		
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	92	-	421	1			577	1		
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	92	-	421	1			577	1		
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	92	-	416	6			572	6		
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	92	-	XXX				578	-		
17.	Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн нөөц сан	86	6	XXX				572	6		
18.	Өрийн бичгийн зохистой харьцаа	90	2	418	4			572	6		
19.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	92	-	418	4			63	1	573	5


Тайлбар: √ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо, X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу байгуулсан 28 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 6 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 6 ББСБ, өрийн бичгийн зохистой харьцаа алдагдсан 6 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 5 ББСБ байгаа нь хамгийн их алдагдсан харьцаа үзүүлэлтүүд байна.

Өгөөжийн үзүүлэлтүүд

2026 оны I улирлын байдлаар салбарын нийт хөрөнгийн өгөөж 3.2 хувь нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 пунктээр буурч, харин өөрийн хөрөнгийн өгөөж 6.0 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.8 пунктээр буурсан байна.

Зураг 19 Салбарын өгөөжийн үзүүлэлт сүүлийн 5 жилээр



Гадаад валютын арилжааны мэдээ

Тайлант хугацаанд буюу 2026 оны I улирлын байдлаар гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 167 ББСБ-аас ирүүлсэн тайлан мэдээгээр 1.9 их наяд төгрөгийн валют худалдан авсан нь банкны салбарын 9.7 хувьтай, 1.9 их наяд төгрөгийн валют зарсан нь банкны салбарын 12.1 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 37 2026 оны I улирлын байдлаарх валют арилжааны мэдээ (сая төгрөгөөр)

	Нийт дүн Авсан	Нийт дүн Зарсан	1-р сар Авсан	1-р сар Зарсан	2-р сар Авсан	2-р сар Зарсан	3-р сар Авсан	3-р сар Зарсан
Нийт дүн	1,883,275.4	1,851,873.9	589,913.1	563,579.6	510,677.7	461,693.7	782,684.7	826,600.6
АНУ доллар	898,942.3	823,347.0	267,523.9	252,951.5	252,301.8	230,821.0	379,116.5	339,574.5
ОХУ-ын рубль	303,362.4	305,435.1	73,306.5	74,517.1	99,515.8	74,026.3	130,540.1	156,891.7
БНХАУ-ын юань	527,171.6	550,451.1	201,427.0	182,213.2	115,202.5	107,924.4	210,542.0	260,313.4
БНСУ-ын вон	34,040.2	37,324.4	10,256.9	9,721.2	10,551.3	11,955.9	13,232.0	15,647.2
Евро	78,466.5	82,716.4	25,874.1	27,384.3	18,975.7	20,557.9	33,616.8	34,774.3
Японы иен	22,092.9	30,531.2	5,886.8	8,758.8	6,307.7	8,585.5	9,898.4	13,186.9
Казахстан тэнгэ	6.0	6.0	-	-	2.2	2.3	3.8	3.8
Английн фунт	635.6	490.1	255.7	136.4	220.9	169.7	158.9	184.0
Австралийн доллар	3,349.8	3,782.5	990.6	1,171.6	1,212.4	1,280.1	1,146.9	1,330.9
Сингапур доллар	3,494.5	6,237.7	1,455.1	3,798.0	1,245.8	1,506.2	793.6	933.5
Хонгконг доллар	3,292.4	3,603.3	1,244.7	1,402.1	885.8	1,008.8	1,161.9	1,192.4
Канадын доллар	268.1	210.1	53.3	12.4	81.8	55.1	133.0	142.6
Швейцар франк	8,069.5	7,670.1	1,588.3	1,479.3	4,150.3	3,779.5	2,331.0	2,411.2
Шведийн крон	30.4	13.6	23.5	6.5	1.1	1.0	5.8	6.1
Тайван доллар	2.5	2.6	-	-	2.5	2.6	-	-
Тайланд бат	49.1	51.4	25.4	27.2	19.7	16.2	4.0	8.0
Индонезийн рупи	1.2	1.2	1.2	-	-	1.2	-	-
Польшийн злот	0.3	-	-	-	0.3	-	-	-

Дүгнэлт

2026 оны I улирлын тайлан мэдээний ирц 97.1% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 578 ББСБ-аас 561 ББСБ жилийн тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 11 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 6 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа. 2026 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 44,439 хувьцаа эзэмшигчдийн 578 ББСБ, 603 салбар нэгж, 10 төлөөлөгчийн газар, 6,866 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.3 сая харилцагчид үйлчилгээ үзүүлж, 3.5 сая зээлдэгчид /давхардаагүй 768,150/ хүрч үйлчилж байна.

Актив, пассивын бүтэц

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар өсөж, банкны салбарын 11.3%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 128.7%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.3 пунктээр өссөн дүн юм.

2026 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар буюу 2.0 их наяд төгрөгөөр өсөж 9.6 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 72.0 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 62.4 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

ББСБ-ууд нь ихэвчлэн өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогтой байсан хэдий ч сүүлийн жилүүдэд бусдаас итгэлцэл, өрийн бичиг, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр хэлбэрээр мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар эх үүсвэр татах нь нэмэгдэж байгаа тул тэдгээр /161 ББСБ/ ББСБ-уудын тайлан мэдээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 23.6 хувь буюу 1.6 их наяд төгрөгөөр өсөж 2026 оны I улирлын байдлаар 8.1 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 505.6 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 7.6 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Зээлийн багцын 85.0 хувийг буюу 6.6 их наяд төгрөгийг хэвийн зээл, 6.1 хувийг буюу 469.7 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 8.9 хувийг буюу 693.7 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 3.7 пунктээр буурсан бол, чанаргүй зээлийн хувь 2.2, анхаарал хандуулах зээлийн хувь 1.5 пунктээр тус тус өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 1.2 их наяд төгрөгийн үлдэгдлийн 45.7 хувьд буюу 505.6 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй 82 ББСБ 77 финтек зээлийн аппликэйшнээр дамжуулж цахим зээлийн үйлчилгээ үзүүлж байна.

2026 оны I улирлын байдлаар ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 3.2 сая зээлдэгчийн 2.6 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 92.0 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 34.0 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 828.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 22.4 дахин бага байна.

Өмнөх оны мөн үеэс финтек зээлдэгчийн тоо 39.4 хувиар өсөн 3,191,501-г хүрч, зээлийн үлдэгдлийн хэмжээ 44.0% буюу 0.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд 31 ББСБ 10,868 зээлдэгчид 42.1 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 2.8 хувийн хүүтэйгээр олгож, 41 ББСБ-ын 11,278 зээлдэгчээс 46.3 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2026 оны I улирлын байдлаар 48 ББСБ 16,757 зээлдэгчийн 132.8 тэрбум

төгрөгийн “ногоон” зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 1.7%-тай тэнцэж байна.

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар буюу 2.0 их наяд төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 37.6 хувийг өр төлбөрийн өсөлт, 62.4 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 1.3 дахин, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 1.0 дахин, бусад эх үүсвэр 1.0 дахин, үүсмэл санхүүгийн өр төлбөр 0.5 дахин, бусад санхүүгийн өр төлбөр 2.3 дахин, барагдуулах ёстой хоёрдогч өглөгийн өр төлбөр 38.4 дахин өссөн бол өөрийн хөрөнгөөс хуримтлагдсан ашиг 35.4 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 28.2 хувиар, нэмж төлөгдсөн капитал 24.5 хувиар тус тус өссөн байна.

Ашигт ажиллагаа

2026 оны I улирлын байдлаар ББСБ-ууд 772.1 тэрбум төгрөгийн орлого олж, 500.2 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 271.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 28.0% буюу 168.7 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 34.7% буюу 128.9 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 17.1% буюу 39.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2026 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 578 ББСБ-ын 86.9% буюу 502 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 13.1% нь буюу 76 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 64 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 11 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу байгуулсан 28 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 6 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 6 ББСБ, өрийн бичгийн зохистой харьцаа алдагдсан 6 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 5 ББСБ байгаа нь хамгийн их алдагдсан харьцаа үзүүлэлтүүд байна.